Ярилцлага өгөгчийн нэр	Дамдин	Дугаар	L355
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Эрдэнэдалай сум
Төрсөн газар	Эрдэнэдалай сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Тус хийдийн дуганч лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сум хийд	Хадан усны хийд	Сум хийдийн дугаар	ДУЭД 005
Одоогийн сум хийд	Эрдэнэдалайн хийд	Сум хийдийн дугаар	ДУЭД 002
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-рсарын24	Ярилцлага авсан хүн	Жужа

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Хадан усны хийд, Дамбадаржаалин хийд

Жужа: Энд ойролцоогоор хэдэн лам байсан бэ?

Дамдин: Аан, хуралд үү? Энд мань мэттэйгээ нийлээд зүү гаруй лам байсан байх.

Жужа: Энд хамба лам нь хэн байсан бэ?

Дамдин: Хамба ламыг нь аль түрүүн бариад алаад хаячихсан байх аа/ инээв/

Жужа: Энд ямар ямар дуганууд байсан бэ?

Дамдин: Цогчин дуган гэж арай хожуу барьсан шинэ дуган байсан. Түрүүнд нь дарь эхийн дуган, барүүн дацан, зүүн дацан гэж 2 дацан байсан. Жүдийн дуган гэж сүүлд нь барьсан байсан.

Жужа: Энэ дуганууд бүгд модоор барьсан байсан уу, тоосгоор барьсан дуган байсан уу?

Дамдин: тоосгон дуган байсан. Тэр цогчин жас нь тоосгон дуган байсан. Тэр их сайхан дуган байсан. Энэ Далай дээр байдаг дүганыг үзээ биз дээ.

Энхбаяр: Үзсэн.

Дамдин: Яг тэрэн шиг сайхан их гоё дуган байсан.

Жужа: Нөгөө дуганууд нь мод байсан уу?

Дамдин: Тиймээ тийм, модон дуган байсан.Модон дугануудыг нь бүгдийг нь бүүлгаж аваачаад ачаад явчихсан. Харин тэр дарь эхийн дуган нь нэлээд хүүчин цагийн шавраар барьсан дуган байсан болов уу.

Энхбаяр: Өвгөөн, нэг ийм бүдүүвч гаргаадахая. Цогчин дуган ингээд голд байлаа гэхэд дарь эхийн дуган нь хаана байх?

Дамдин: Дарь эхийн дуган халз хойно нь. Хоёр талд нь барүүн зүүн дацангууд нь байсан.

Энхбаяр: Жүдийн дуган нь хаанаа?

Дамдин: Зүүн дацангийн хойно нь байсан.

Энхбаяр: Хэрмэн хашаатай байсан уу?

Дамдин: Аан, хашаагүй задгай байсан.Тэгээд жасууд нь түсдаа.

Энхбаяр: Энд түүрийн хойгуур жижиг байшингийн ул мөр их байна. Энэ юун байшингуудын ул мөр юм бол?

Дамдин: Аан энэ чинь хөдөөний айлуудын амбаар савны ул мөр. Лам нарын байшингууд ихэнх нь байх. Эд нар чинь тэгээд дандаа хэрмэн хашаануудтай байсан.

Энхбаяр: Хэрмэн хашаа нь намхан байсан уу?

Дамдин: Намхаан намхан.

Энхбаяр: Бааюу байсан уу?

Дамдин: Аан, байсан байсан. Тэр барүүн өмнө талд нэг бааю , зүүн хойд талд нэг бааю байсан. Бас нөгөө юу билээ дээ, өө үхаан байхгүй болчихоод юм санахаа байсан. Яахав нөгөө цагаан юу шатаагаад ингүйлээд юу гаргаад байдаг...

Энхбаяр: Шохойн чулуу шатаах?

Дамдин: Тийм тийм. Шохой шатааж байсан.

Жужа: Суварга байсан уу?

Дамдин: Аан, / чих нь сонсохгүй учир дахин дахин хэлүүлж байж ойлгов./ Өө байлгүй яахав. Хийдийн хойно нь хоёр.

Энхбаяр: Хойноо гэж дарь эхийн дуганы хойно уу?

Дамдин: Тийм, тийм. Түүний хойд талд хоёр сайхан том суварга байсан. Түүнийг чинь бүүлгаж нураагаад хүн амьтан дотроос нь юм авахад өдий чинээ алт байсан гэж хүн амьтан ярьдаг юм.

Энхбаяр: Аан, шүншигнийх нь алт байж. өөр суварга байсан уу?

Дамдин: Өөр суварга байгаагүй. харин энэ хоёр сувargаны өмнө хоёр том хүрд байсан. Ганжуур, данжуурын хүрд гэж. Хоёр хүрдний голд нэг тийм гурвалжин гэмээр санаж байна.Тийм байшин байсан, тэнд нөгөө цамын баг хувцас хэрэгслээ хадгалдаг байсан санаж байна. Тэгээд л тэндээс чинь би цамын баг зөөж гүйдэг л байлаа.

Энхбаяр: Хичнээн баг байсан юм бол оо?

Дамдин: Хоёр азрын баг, хашин хааны баг, хашин хааны долоон хүүхдийн баг, хоёр ботгын баг тийм юм байсан. Тэр хашин хаан гэдэг нь долоон хүүхэд дагүүлаад явдаг байсан.

Энхбаяр: Чойжоо байсан уу, тийм үхэр унасан?

Дамдин: Чойжоо? Үгүй ээ, манай энд байгаагүй. Харин Далайн хүрээнд байсан юм.

Энхбаяр: Ганжуур эргэх, майдар эргэх, сор залах зэрэг зан үйл байсан уу? Эд нар байсан бол хэзээ хэзээ яаж хийдэг байсан талаар хэлж өгнө үү?

Дамдин: Байсан байсан. Байлгүй яахав.Намар майдар эргэдэг, дөрвөн дугуйтай хадаг яндар болсон гоёмсог тэргэнд бурхан шүтээнээ залаад, олон лам нар түрээд л хурлаа тойрч явна. Тэгэхэд нэг лам тэнд цугласан хүн амьтанд том том судраар адис хүртгээгээд явдаг байсан юм.

Энхбаяр: Ганжуураа хэзээ хүрдаг байсан юм бол?

Дамдин: Өө ганжуурыг уншина , уншина. Ганжуур данжуур хурна гээд л одоо Гандан гэдэг юм даа, дан мөнгөөр хийчихсэн үрт юм үлээгээд л, дан мөнгөөр хийсэн. Манай энэ чинь их баян жас байсан юм.

Энхбаяр: Хайлан хүрдаг байсан уу?

Дамдин: Хайлан хуралгүй яахав. Хайлан хурна гээд л хайлангийн лам нар гээд л /хөхрөв/ хурлаа тарчихаад хөдөөний айлуудыг хэсээд л айраг уугаад л найралцгаана.

Энхбаяр: Хайлангаа хаанаа хүрдаг байсан юм бэ?

Дамдин: Хайлангийн дуган гэж түсдаа дуган байгаагүй. Цогчин дугандаа л хүрдаг байсан. Дарь эхийн дуганд бол дарь эх л хурна. Уг нь эхэн үедээ энэ Дарь эхийн дуганд бүх юмаа хийдэг байсан юм. Сүүлдээ хэд хэдэн дуган баригдаад больсон юм.

Энхбаяр: Хийдийн гол сахиус нь ямар сахиус байсан юм?

Дамдин: Өө би мэдэхгүй. Бүрхан тахил талыг нь би нарийн сайн мэдэхгүй.

Энхбаяр: Зоч лам байсан уу, лүйжин тавих гэх мэт юм байсан уу?

Дамдин: Өө тийм юм байхгүй. Харин энэ урдуур манай бригадын төвийн баруунтаа нэг хашаа байгаа биз дээ, тэнд чинь их олон зоч нар байсан юм. Тэнд нэг жасархүү юм байсан юм. Их олон зоч нар байсан. Авгай хүүхэн, чавганц нар ч байсан. Аа мундаг том зоч нар ч байсан. Сахал Чимэд-Очир гэж тийм нэг ширвээ сахалтай хүн хамгийн том тэргүүн нь байсан.

Энхбаяр: Тэнд тэгээд дуган байсан юм уу?

Дамдин: Үгүй ээ, одоо нэг дуганархүү тийм нэг байшин байсан. Зоч нар чинь хүрал хурна шүү дээ, бас. Тийм нэг хүрдаг байшин байсан юм. Тэр зүүн хойхонтой нь нэг гудгэр дээр овоо бий. Овооныхоо өмнө суварга байсан юм. Бас голын лам гэж энэ голын нэртэй том зоч лам тэр зоч нартай цуг байсан юм.

Энхбаяр: Энэ гол ямар нэртэй гол вэ?

Дамдин: Хашаатын гол гэдэг нэртэй.

Энхбаяр: Яг тэр зоч нарын дуган бригадын төвийнхөө аль хэсэгт байсан юм бэ?

Дамдин: Бригадын төвийн баруухантай нэгэн ус байгаа. Тэр усны зүүн талд тэр дуган нь байсан юм. Хойд талын овооны хүүчин суварганы бүүрин дээр нуднин үржнан хоёр суварга шинээр босгосон байна лээ.

Энхбаяр: Хадан усны хийд маань хэдэн онд хаагдсан бэ?

Дамдин: Үгүй ээ одоо сайн хэлж мэдэхгүй юм, хорин хэдэн онд юм уу. Намайг цэрэгт явахаас өмнө л хаагдсан юмдаг. Бүх лам нарыг нь бариад аваад явчихсан.

Энхбаяр: Та хэдэн онд төрсөн бэ?

Дамдин: Мянга есөн зүүн арван хэдэн онд юм уу, яг мэдэхгүй байна.

Энхбаяр: Та тэгвэл хэдэн онд цэрэгт явсан бэ?

Дамдин: Хорин есөн онд явсан. Би чинь их хожуу цэрэгт явсан. Лам байсан учраас, тэгээд намайгцэрэгт татахгүй. Лам нарын татвар гэж 400 төгрөг хүртэл авч байлаа. Лам нарыг нь ганцхан шөнө л барьж аваад

явчихсан юм. Гэхдээ мань мэтийг тоож бариагүй. Би нэг ламархүү ухаантай л явсан юм, гэхдээ ан хийдэг лам явж /хөхрөв/

Энхбаяр: Анчин лам байгаа юу?

Дамдин: Тийм ээ, дандаа түулай ална. Түулайгий чинь хурааж байгаад л хоршоонд аваачиж өгнө. Тэгээд гурил авч хоолондоо нэмэрлэнэ. Тийм л лам явж. Тэгээд л хар болоод цэрэгт явсан.

Энхбаяр: Хийдийн хамба лам тэргүүн лам нар ямар хүмүүс байсныг мэдэх үү?

Дамдин: Үгүй мэдэлгүй яахав. Хэд хэдэн том лам нар байсан юм. Үгүй одоо нэрийг нь... / түр бодолхийлэв /

Энхбаяр: Санах нь уу?

Дамдин: Үгүй, тухайн үедээ дандаа л багш л гэдэг байсан болохоор яг нэрийг нь одоо санахгүй байна. Дүүрчихсэн золиг, мүүхан хүн дээ, би чинь одоо.

Энхбаяр: Шинийн найман, арван таван гээд дүйчэн өдрүүдэд ямар ямар хурал хурдаг байсан бэ?

Дамдин: Одоо санахгүй байна. Их л сайхан хуралтай байсан юм даг. Хурлуудаар манай энэ хавийн хүн ард их цуглана. Их ч малтай, адуу сайтай нутаг. Их ч баян жас байсан. Гүү барьсан айлууд хурлын үеэр нэг айл л гэхэд хоёроос гурван тэмээнд айргаа ачиж ирнэ. Тэмээнд айраг ачсан хүвин нь манай энэ гэрийн тооны дайтай амтай, их өндөр модон хүвинд айраг ачиж ирнэ. Тэгээд л бид чинь шат тавьж байгаад л айргийг ачиж бүүлгаад л хурлын лам нар, хуралд ирсэн хүн болгонд л айраг тараана.

Энхбаяр: Хийд хогоо хааш нь хаядаг байсан бэ?

Дамдин: Өө тэр барүүн урдаа хогийн жалга нь байсан.

Энхбаяр: Хийдийн ойролцоо тахидаг овоо гэж байсан уу?

Дамдин: Бий, бий. Тэр урагшаа Хонгорын овоо гэж, баруунтаа Олонгийн овоо гэж овоо бий. Мөн яг хажуудаа багачуулын тахидаг Цогзол овоо гэж бий.

Дамдин: Би лам байсан гээд цэрэгт авахгүй. Тэгсэн мөртөө их хэмжээний алба татвар төлөх хэцүү байсан болохоор цэрэгт явахаар шийдэж хот ороод цэрэг татлагын газар очсон чинь танайхнаас баригдаад явсан лам нар бий юу/ ойр төрлийн / гэж асуухаар нь энэ Хадан усны хийдийн үнзад манай ах лам байж байгаад баригдаад явсан юм. Түүнийг хэлтэл эсэргүүний үлдэгдэл хог новш байна гээд намайг хөөгөөд гаргачихсан. Тэгээд би байж байтал дараа жил нь лам явсан хүмүүсийг цэрэгт авна гэсэн шийд гарч нөгөө эх орны дайны жилийн өмнөхөн цаг төр хүндрэхэд тэгээд би цэрэгт явахчаан болсон. Таван жил гаруй , зургаан жил шахүү цэрэгт байж бага дарга дандаа хийсэн.

Энхбаяр: Та энэ ойр хавийн хүрлуудын газраар хэр явж байсан бэ?

Дамдин: Үгүй, би ер явж байгаагүй. би бол хурлын лам байгаагүй. одоогоор бол аж ахуйн ажил хариуцаж байсан дуганч лам юм даа. Бүх дуганы түлхүүр надад байдаг. Тэгээд л бүрхан тахилыг нь тоос шороог арчина, зул хүжийг нь сэргээнэ, олбог жавдангийг нь тоолно гэх зэрэг. Цэргээс ирээд ерөөсөө л ан хийж амьдарсан. Одоо ч өнгөрч , нас ер гарлаа. Нүд хараа муудсан, чих сонсохоо байсан.